

**“ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН
АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 01 дүгээр
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 02 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Ж.Сүхбаатар нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна.

Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас болон Улсын Их Хурлын гишүүдээс “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтад заасан “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам” тус бүрээр Улсын Их Хурлын тогтоол гаргах нь зүйтэй гэж үзсэн тул Төрийн байгуулалтын байнгын хороо 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах “Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Ажлын хэсэг тогтоолын төслийн дагаж мөрдөх хугацааг тодорхой заах, Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэл хангах, Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зэрэг зарчмын зөрүүтэй 12 санал, найруулгын 2 санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах “Журам батлах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Ж.МӨНХБАТ